

лөх гэсэн сака'архал энх тайванд аюул занал учруулж о'айгаа-
гийн эсрэг тэмцэх зориг ыийдвэр төгөлдөр байгаагаа илэрхийлэн,

германы асуудлыг эхх тайвнаар зохицуулах урьдчилсан унд-
сэн нөхцөл бол Өрнөд Герман дахь милитаризм болон шинэ нациз-
мыг ялан давах явдал мөн гэж ухамсарлан, олон улсын эрхийн
нийтээр хулээн зөвшөөрсөн зарчмын дагуу Бугд Найрамдах Ард-
чилсан Герман Улс, Холбооны Бугд Дайрамдах Герман Улсын хоо-
рондын хэлэлцээрийн дунд Германы хоёр улсын харилцааг хэвийн
болгох замаар л ирээдүйд кэгдмэл, энх тайванч, ардчилсан Гер-
ман улсыг байгуулж болохыг Нотлон,

олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжуулэх хийгээд
Нэгдсэн Хкдэстний Байгууллагын Дурмийн зорилго, зарчмын дагуу
, энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын ундеэн дээр.нийгмийн янз
бүрийн байгуулал бүхий улс гурний хоорондын харилцааг хөгжуу-
лэн өргөтгөх эрмэлзлийг удирдлага болгон,'

БНАГУ, БНМАУ-ын хоорондын найрамдал, хамтын ажиллагааны
тухай Гэрээг 1957 оны наймдугаар сарын 22-нд байгуулснаас
хойш бнгөрсөн хугацаанд Европ, Ази болон дэлхий'дахины байдалд
гарсан өөрчлөлтүүдийг харгалзан узээд энэхуу Гэрээг байгуула-
хаар шийдвэрлэн дор дурдсан зүйлсийн-талаар хэлэлцэн тохиров.
Цнд:

Нэгдүгээр зүйл

Хэлэлцэн Тохирогч'Зрхэм хоёр Этгээд ах дуугийн найрам-
дал, нягт хамтран ажиллах, бие биедээ туслах харилцааг социа-
лист интернационализм болон адил тэгш эрх, харилцан ашигтай
байх, төрийн бүрэн эрхт байдлыг хундэтгэх, нэг нэгийнхээ доюод
хэрэгт ул оролцох ариун дээд зарчмын ундеэн дээр цаашид бух
талаар' бэхжуулэн хөгжуулнэ*